



## Үхэгсдийн орон Мосегийн хэлснээр Мөнхийн зовлонт там биш

Библид “мөнх” гэж орчуулсан еврей, грек үг “хэзээ төгсөх нь тодорхойгүй урт удаан цаг хугацаа”-г хэлдгийг бид өөр нэгэн судалгаанд тодорхой авч үзсэн билээ. Энэ үгийг бид монгол утгаар нь буюу “юмс үзэгдлийн хувирч өөрчлөгдөхгүй, харьцангуй бат бэх орших чанар” гэдгээр ч ойлгож болно. Гэтэл теологичдийн заадаг “ямар ч эцэс төгсгөлгүй” гэсэн утга энэ үгэнд алга юм. Нэгэнт тийм байхад мөнхийн зовлонт тамын газар байдаг гэж үү? Энэ талаар энэ цуврал судалгаа авч үзэх болно.

“Там” гэж сонсонгуутаа шууд орж ирдэг нэг тодорхой ойлголт Монгол хүнд байдаг. “Там” нь “тамлах”, “тамлуулах” буюу зовлонтой холбоотой үг болох нь илэрхий. [Онлайн Цэвэлийн толийн](#) дагуу там “*шашны ёсны гурван муу заяа гээчийн нэг, зовлон эдлүүлж зовоох газар*” ба шилжсэн утгаар “*зовлон гаслантай орон*” эсвэл “*маш гүнзгий нүх*” гэсэн утгатай (там газрын бүр гүнд байдаг гэсэн ойлголт үүнээс харагдана). [Онлайн монгол толийн](#) дагуу там нь “*үхэгсдийн сүнсийг зовлон эдлүүлж тарчилгах газар*”. Шилжсэн утгаар “*амьд яваа насны зовлон зүдүүр, гаслан*”.



“Тамын зовлон” бол “хамгийн хэцүү аймшигт зовлон”. Бодит зүйлийг хэлсэн тохиолдолд там “маш гүнзгий нүх” байхаас гадна “шорон, гяндан” гэсэн утгатай байж болно. Энэ бүхнээс харахад монгол хүний сэтгэлгээнд шингэсэн ойлголтын дагуу үхэгсдийн очих там нь газрын гүнд буй, сүнс нь зовж тамлагдах гяндан билээ.

Тэгээд Библиэс “там” гэсэн үгийг уншихдаа монгол хүн өөрийн эрхгүй тийм л газрыг төсөөлж бодно. Гэтэл Библийн эхийг бичсэн еврейчүүдэд монгол тамтай адил төстэй ойлголт байсан уу?

Олон христитгэлт теологич, пастораас асуувал “тийм” гэж хариулна. Тэдний ярьдаг “там” монголчуудын ярьдаг тамаас бараг ялгаагүй. Мэдээж, “там”, “мөнхийн зовлон” хоёулаа Библийн монгол орчуулганд орсон хэллэг учраас ямар нэгэн грек, еврей үгийг орчуулсан

болж таарна. Иймд “Библийн эх хэл дээр байгаа тэр үг ямар утгатай вэ?” гэж асуувал зохино.





## **«Хуучин Гэрээ»-нд: Үхэгсдийн Орон**


Хүн бүр нас барахдаа “Шеол”-д ([לִישׁוֹן](#), [Sheol](#), H7585)<sup>1</sup> ордог гэдгийг «Хуучин Гэрээ»-нд заадаг. Энэ үг нийт 65 удаа гардаг. 1611 онд анх Английн Жаймс Хааны тушаалаар орчуулагдаад өдий хүртэл өргөн хэрэглэгддэг *King James* Библид энэ үгийг ихэвчлэн “hell” буюу “там” гэж орчуулсан байдаг. Гэвч орчин үеийн орчуулагч нар энэ үгийг “булш”, “үхэгсдийн орон” зэрэг зөв орчуулдаг болсныг Ариун Библи дагаж энэ үгийг мөн “Үхэгсдийн орон” гэж орчуулдаг. Тэгэхээр «Хуучин Гэрээ»-нд “там” гэсэн үг монгол Библийн орчуулганд нэг ч удаа гардаггүй. Та үүнийг Библийн аппын хайлтаар богино хугацаанд өөрөө шалгаж болно. Гэсэн хэдий ч, Жаймс Хааны орчуулга өдий хүртэл англи ертөнцөд маш их хэрэглэгддэг хэвээр бөгөөд хүмүүсийн тамын тухай төсөөлөлд маш их нөлөөлсөн хэвээрээ.

---

1 Аливаа үгийн үнэн утгыг тогтоохоор үгийн сангийн судлаачдын гаргасан толь бичгээс илүү Библи дээрх тухайн үгийн хэрэглээ нь найдвартай ойлголтыг өгнө. Библи дээр гарч байгаа тухайн үгийн бүх тохиолдлыг олоход “конкорданс” хэмээх толь үнэлж баршгүй ашиг тус үзүүлнэ. Конкорданс бол Библийн бүх үгийг цагаан толгойн дэс дараагаар багтаадаг. Үг бүрийн доор хаана хаана гардаг ишлэлүүд Библийн номын дарааллаар эмхэтгэн тавигдсан. Бидний оруулсан линк Strong-ийн гаргасан Библийн үгийн онлайн толь бичигийн еврей “Шеол” хэмээх хуудсыг нээнэ (H7585). Уг үгийн тайлбарыг англиар тавьсны дараа «Хуучин Гэрээ»-нд гардаг бүх ишлэлийн жагсаалтыг багтаасан. Англи хэл мэдэхгүй хүн ч гэсэн тэдгээр ишлэлийг тэмдэглэн авч монгол Библиэс олж уншиж болно. Энэ хуудас мөн тэр үг «Хуучин Гэрээ»-нд хэдэн удаа гардагийг шууд заана.



Улмаар, Шеол гэсэн үг бас «Шинэ Гэрээ»-нд грек хэлбэрээр нь гардаг учраас авч үзэх нь чухал.



“Үхэгсдийн орон гэдэг чинь тамын нэг нэр байхгүй юу” гэж үздэг хүмүүс бий. Энэ үзлийг Бичвэрүүдээр шалгая.

Хэрэв там...

1. дуулгаваргүй муу хүмүүсийн очиж...
2. Бүтээгч Эзэнээсээ үүрд салаад...
3. мөнхөд гаслан зовох...
4. хэзээ ч гарч чадахгүй байнгын оршин суух газар нь юм бол...

...үхэгсдийн орон лав тийм газар биш!

Үхэгсдийн орны тухай Библи юу гэж заадгийг товчхон авч үзэхэд:



1. Зөвхөн Ертөнцийн Эзэнд дуулгаваргүй хүмүүс зогсохгүй, хүн болгон Үхэгсдийн оронд очдог. Үүнд: **“Наран доорх бүх юмсад буюу бүх хүнд нэг л хувь зохиол байдаг нь бузар юм... тэд үхэл уруу одох ажээ... Гар чинь юуг хийхээр тэмүүлнэ, түүнийг бүхий л чадлаараа хийгтүн. Учир нь чиний очих Үхэгсдийн оронд мэргэн ухаан, ажил үйлс, бодох сэтгэх гэдэг нь байхгүй.”** (Номлогчийн үгс 9:3,8). Яахоб (Эхлэл 42:38; 44:29,31) Иов (14:13), Давид (6:4-5; 16:10; 88:3), Хезекиа хаан (Исаиа 38:10) зэрэг Их Эзэний хүмүүс хүртэл өөрийгөө тийшээ орохыг мэддэг байсан. Есүс хүртэл Үхэгсдийн оронд орсон (Дуулал 16:10 - Үйлс 2:31).
2. Бүтээгч Эзэн үхэгсдийн оронд ч байдаг. Тухайлбал:  
**“Хэрэв би тэнгэр өөд очвол, Та тэнд байдаг. Хэрэв би Үхэгсдийн оронд ор дэрээ засвал, харагтун, Та тэнд байдаг”** (Дуулал 139:8).  
Жич: Энэ ишлэлээс Үхэгсдийн орон “нойрсох” газар болох нь тод харагдана.
3. Үхэгсдийн оронд буй хүмүүс гаслан зовдоггүй. Харин ч **“үхэгсэд юу ч мэддэггүй аж... Тэдний хайр, хорсол, атаа жетөө хэдийн мөхөж, (...)**



**Үхэгсдийн оронд мэргэн ухаан, ажил үйлс, бодох сэтгэх гэдэг нь байхгүй.”**  
(Номлогчийн үгс 9:5-6+10).

Үхэгсэд “анир чимээгүй уруу доош” одсон байдаг (Дуулал 115:17). Юу ч болохгүй тэр анир чимээгүйд гаслах дуу ч лав хадахгүй. “Мартахуйн газар” болох тэр оронд хүмүүс юу ч мэдэхгүй, юу ч мэдэрдэггүй учраас зовохгүй, гаслахгүй нь мэдээж (Дуулал 88:12).

4. Бүтээгч Эзэн хүнийг үхэгсдийн орноос гаргадаг: **“ЭЗЭН үхүүлдэг, бас амьдруулдаг. Үхэгсдийн оронд унагадаг, бас босгодог.”** (1 Самуел 2:6). **“Та миний сэтгэлийг Үхэгсдийн оронд орхихгүй...”** (Дуулал 16:10). Ертөнцийн Эзэн **“миний сэтгэлийг Үхэгсдийн орны эрхшээлээс аварна. Учир нь Тэр намайг хүлээн авна.”** (Дуулал 49:15). Энэ бол Түүний амласан дахин амилалт мөн. Хэн ч үүрд мөнхөд үхэгсдийн оронд үлдэхгүй.

Энэ бүхнээс харахад **“Үхэгсдийн орон”** ердөө л **булш бунхан, үхэл эсвэл нас барсан хүний байгаа байдлыг (нарийн хэлэхэд, үл орших байдлыг нь)** илэрхийлэх шилжсэн утгатай үг.



Монголын Библийн Нийгэмлэгийн гаргасан орчуулганд ч гэсэн энэ үгийг “үхлийн булш”, “хар үхэл”, “үхэгсдийн ертөнц”, “үхдэлийн ертөнц” гэх мэт хэд хэдэн янзаар орчуулсан ч гэсэн ижил утгатай байна.

Анзаарахад, Христитгэлт сүм чуулганд заагддаг тамын ойлголт энэ үгэнд алга. Энэхүү “орон” нас барсан хүний очдог булш болохоос өөр бодит газар биш.



Зарим нь энэ дүгнэлтийг үгүйсгэн, Тооллого 16-т гардаг түүхийг “амьдаар нь тамд орсон хүмүүсийн тухай” гэж хэлдэг. “Бор” Библийн орчуулга энэ явдлыг тод үгээр дүрсэлдэг. Тухайлбал:



**“Тэр хүмүүсийн зогсч байсан газар гэнэт хага үсрэн, том ангал үүсээд тэднийг гал голомттой нь хамт юу ч үгүй ховх сорон, [тэд] газрын гаваар далд орцгоолоо. Ийнхүү тэд өөрсдийн гэсэн бүх юмны хамт амьдаараа авслуулан удалгүй өнөөх ангал ч дахин хаагдаж, тэр хүмүүс олны дундаас ор сураггүй алга болжээ”**  
(Тооллого 16:31-33, ББ).



Ариун Библи “амьдаараа авслуулсан” тэр хүмүүсийг “Үхэгсдийн орон руу доош оржээ” гэж орчуулав. Амьдаараа газарт залгигдсан тэд амь алдаж нэгмөсөн булшлагдсан гэсэн утгатай болох нь ойлгомжтой.


Улмаар, бүх майхан гэр ба дотор нь байсан бүх эд хогшил нь тэдний хамт “Үхэгсдийн орон”-д



оржээ. “Үхэгсдийн орон”-г там гэж ойлгох ёстой гэвэл хүний эд хөрөнгө ч хамт тамд очдог гэсэн сонирхолтой ч буруу онолыг гаргахад хүрнэ. Үүнээс ч харахад Үхэгсдийн орон үхлийн булшийг хэлдэг.

Эцэст нь Хуучин Гэрээний тамын тухай сургаалыг дүгнэж үзвэл хамгийн чухал санаж явах зүйл бол энэ: *«Хуучин Гэрээ»-нд “там” гэдэг үг ч алга, мөнхийн мөнхөд тамлуулах тухай төсөөлөл ч байхгүй. Хүн хийсэн хэргийнхээ төлөө хэзээ ч дуусашгүй шийтгэл авна гэсэн ойлголт алга.*

«Хуучин Гэрээ»-нд олонтоо гардаг Үхэгсдийн орон бол мөнхийн зовлонт тамын газар биш болох нь тодорхой болсон. «Хуучин Гэрээ»-нд там байхгүй.



Энэ талаар эргэцүүлэн бодохоор нэг асуулт төрнө. Тухайлбал: Хэрэв там үнэхээр мөнхийн мөнхөд үргэлжлэх зовлон мөн юм бол, бас ихэнх хүмүүс тэр аймшигтай хувь тавиланг зорьж яваа байгаа бол, Ертөнцийн Эзэн яагаад Библийн хуудас бүрд хүн төрөлхтөнийг энэ аюулаас болгоомжлуулаагүй юм бэ?



Анх Адамд энэ аймшгийн шийтгэлийн талаар сэрэмжлүүлэх ёстой байсан биш үү? Адам хэзээ ч тамын тухай сонсоогүй. Аврахам, Мосе, Давид хаан, Исаиа бүгд тамын тухай юу ч мэддэггүй, хүн мөнхөд шийтгүүлж зовно гэсэн ойлголтгүй байсан. Тамд орно гэсэн айдас «Хуучин Гэрээ»-ний хүмүүст байсангүй. Яагаад тэр вэ?



### **Үхэгсдийн орон «Шинэ Гэрээ»-нд: Хадес**

«Шинэ Гэрээ»-нд Үхэгсдийн орон мөн адил гардаг. Дуулал 16:10-н “Та намайг Үхэгсдийн Оронд орхихгүй” гэснийг Үйлс 2:27-т иш татснаас еврей “Шеол” гэсэн үгийн грек орчуулга нь “Хадес” ᾍδης, hadēs, G86) болох нь нотлогддог. Энэ үг «Шинэ Гэрээ»-нд нийт 11 удаа гардаг.



Грек домгонд “Хадес” гэдэг нь мөн адил Үхэгсдийн оронг хэлдэг бөгөөд тус орны бурхан хааны нэр юм. Гэтэл грек домгийн Үхэгсдийн орон «Хуучин Гэрээ»-ний Үхэгсдийн орноос эрс өөр шинж чанартай.

Ертөнцийн Эзэний үг дотроо зөрчилдөхгүй учраас «Шинэ Гэрээ»-ний Хадес нь «Хуучин Гэрээ»-ний Үхэгсдийн Оронтой адилхан ойлголтыг агуулна гэсэн үг. «Шинэ Гэрээ»-ний Хадес мөн адил бодит утгаараа булш бунханыг хэлнэ, харин шилжсэн утгаараа үхэл эсвэл үхэгсдийн үл орших байдлыг илэрхийлсэн дүрслэлийн үг.

Алдартай [Strong-ын толь бичигт](#) хадес-ыг “a-eido” буюу “харагдашгүй”, “мэдэгдэшгүй” гэдгээс гаралтай гэж тайлбарладаг нь энэ утгыг мөн дэмждэг.<sup>2</sup>

Дараах ишлэлд “харагдашгүй” гэсэн утга нь бий. Үүнд:

---

2 Энэ үг орсон бүх ишлэл судлах хүсэлтэй хүн линкийг нээж 1-р зүүлт тайлбарт бичсэн зааврыг дагаж болно. Гэтэл танд амар болгохын үүднээс Хадес гэдэг үг гардаг бүх ишлэлийг энд дурдья: Матай 11:23, 16:18, Лук 10:15, 16:23, Үйлс 2:27+31, Илчлэл 1:18, 6:8, 20:13+14.



**“Капернаум аа, чи тэнгэрт тултал өргөмжлөгдсөн байх уу? Чи Үхэгсдийн оронд унах болно. Хэрэв та нарт [грек: чиний дотор] учирсан гайхамшгууд нь Содомд тохиолдсон бол тэр хот энэ өдрийг хүртэл үлдэх байсан” (Матай 11:23).**

Сонирхол татам энэ ишлэлд хувь хүн биш, бүхэл бүтэн хот “Үхэгсдийн орон”-д орох тухай гарна. Энэ нь хотын иргэдийг хэлээгүйг бид Содом хотын тухай хэлсэн үгээс мэднэ. Содом Есүсийн хийсэн тийм гайхамшгуудыг харсан бол “энэ өдрийг хүртэл үлдэх байсан” нь Аврахаамын үед амьдарч байсан иргэдийг нь хэлээгүй нь ойлгомжтой. Өнөөдөр Израйль улс очиж Капернаум хотыг хайвал эвдэрхий балгасаас өөр юу ч олдохгүй. Тэр сайхан хот үнэхээр “харагдашгүй байдал”-д орсон.





Үхэгсдийн орон тэгвэл мөнхийн зовлонт тамын газар биш болох нь энэ ишлэлээр ч гэсэн батлагдаж байна.

Үхэгсдийн орны тухай дээр бичсэн бүхнийг үгүйсгэх бололтой ганц тохиолдол Лук 16:23-т гардаг. Энэ бол “баян хүн, ядуу Лазар хоёр”-ын сургаалт үлгэр юм. Баян хүн нас барсан хүний ёсоор “там” биш, “Үхэгсдийн орон”-д оржээ. Гэтэл түүний орсон газрын бүх шинж тэмдэг нь «Хуучин Гэрээ»-д



тодорхойлсон бодит байдалтай огт нийцэхгүй нь анхаарал татна. Түнэр харанхуй, чимээгүй, мартахуйн газар байхын оронд тэнд буй хүмүүс бие биенээ галын гэрэлд харж, ярилцаж, өнгөрснөө санаж бас зовдог эсвэл тухтай байдлыг мэдэрдэг. Таван мэдрэхүйн амьд хүнийх шиг сайн ажилладаг хэвээр.

Та энэ талаар ганц зүйл бодож үзээрэй. Үүнд: Үхэгсдийн орны тухай нэг ишлэл бүхэл бүтэн «Хуучин Гэрээ»-нд гардаг тус орны тухай ойлголтоос илүүд тооцогдох ёстой гэж үү?



“Тийм” гэж хариулсан хүнээс тэгвэл бас асууя:  
“Моше ба Эш үзүүлэгчдийг сонс” гэсэн үлгэрийн  
Абрахамын үг ямар учиртай вэ?  
Моше ба Эш үзүүлэгчдийн үгийг сонсоод  
дүгнэхэд, баян хүн тэдний бичиж байсан  
Үхэгсдийн оронд ороогүй, харин грек домгийн  
Хадест орсон. Тус өгүүлэл бол бодит түүх биш,  
харин үлгэр гэсэн үг. Энэ сургаалт үлгэрийн  
утгын тайлал хийсэн бүхэл бүтэн өөр судалгааг  
дараа нь уншихад таныг урина.

Эцэст нь Үхэгсдийн орны тухай сайхан мэдээ  
дуулгая. Үүнд: “Үхэгсдийн орны түлхүүр”  
Есүсийн гарт байдаг болсон (Илчлэл 1:18). Есүс  
Үхлийг ялан дийлсэн учраас тэр.  
Иймд “Үхэгсдийн орон өөрсдийн доторх  
үхэгсдийг гаргаж өгөх” цаг зайлшгүй ирнэ  
(Илчлэл 20:13).

Гэтэл шүүлтийн үед нэрс нь амийн номд  
байхгүй хүмүүс үхлийн ял авч хоёрдахь үхэлд  
орох болно. Тэд хоёрдахь удаагаа Үхэгсдийн  
оронд хэвтрээ засна гэсэн үг. Гэтэл тэднийг  
агуулсан “Үхэгсдийн орон галт нуурт хаягдан”,  
өөрөөр хэлбэл, тэнд хязгаарлагдах учраас  
шинэ дэлхий дээр үхэл ч байхгүй, булш бунхан  
ч байхгүй байх болно (Илчлэл 20:14, 21:4).



Гэтэл үхэл мөнхөд оршин тогтнохгүй. Үхэл “сүүлчийн дайсан” учраас эцэст нь бусад бүх дайсны адил “устгагдах” болно (1 Коринт 15:26). Тэр үед бүгд Христийн ажлын ачаар “амьд болгогдох” агаад Ертөнцийн Эзэн “бүгдэд бүх юм болох” болно (1 Коринт 15:28). Хамгаас хүчтэй ба мэргэн ухаант Их Эзэндээ талархая! □

*Дараагийн нийтлэлдээ «Шинэ Гэрээ»-нд гардаг хоёр янзын “там”-ыг авч үзэх болно.*

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). [www.blueletterbible.org](http://www.blueletterbible.org)